

**Удирдах ажилтнуудын 11 дүгээр сарын 07-ны өдрийн
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлт**

2022 оны 11 дүгээр сарын 14

№	Өгөгдсөн үүрэг, даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт	Хувь
1.	“Хүнсний хангамж, аюулгүй байдал” зөвлөгөөнд албан хаагчдаа хамруулах, иргэдэд мэдээлэл түгээх, хүнс үйлдвэрлэгч, нийлүүлэгч аж ахуй нэгжүүдийг хамруулах.	11 дүгээр сарын 10 13:00-16:00 цагт	ХБТХОХ, ХХААГ, Бүх байгууллага	“Хүнсний хангамж, аюулгүй байдал” зөвлөгөөний зарыг иргэдэд хүргэж, үйл ажиллагааг зохион байгуулсан. Зөвлөгөөний арга хэмжээнд 35 байгууллагын 150 албан хаагчид хамрагдсан байна.	100
2.	Нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааг журамлах, хууль хяналтын болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах, хяналтыг сайжруулах.	11 дүгээр сарын 10	Сүмбэр сумын Засаг дарга, Авто тээврийн төв	Сумаас нүүрс тээвэрлэлт явуулж байгаа Мак ХХК, Ган элч ХХК, Бигмогул ковул Энд Энержи ХХК, Циркон геологи ХХК, Хуучин андууд ХХК, Болор жонш ХХК-ын тээвэрлэлтийн үйл ажиллагааг түр зогсоож, нүүрсийг тэгшилж янзлах, маршрутын замаар явж байхыг тусгасан албан мэдэгдэл хүргүүлсэн. 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Автотээврийн төвийн дарга, Сүмбэр сумын 4 дүгээр багийн Засаг дарга, Шивээговь сумын Засаг дарга нарын хамт Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргатай уулзаж замын маршрутын талаар санал солилцож, аймгийн Засаг даргад танилцуулахаар ажиллаж байна.	70
3.	Удирдах ажилтны группэд 7 хоног бүр цаг үеийн мэдээллээ хугацаанд нь байршуулах.	11 дүгээр сарын 14	Сумдын Засаг дарга нар, ОБГ, ЦХ, ЭМГ	Удирдах ажилтны фейсбүүк групп хаягт цаг үеийн мэдээллээ Сүмбэр сум, Онцгой байдлын газар, Цагдаагийн хэлтэс, Эрүүл мэндийн газар оруулсан байна.	66.6
4.	Гудамж, талбайн гэрэлтүүлгийг бүрэн асаах, гэрэлтүүлэг асах цагийг 17:30 цаг болгох	11 дүгээр сарын 14	Сүмбэр сумын Засаг дарга, Тохижилт сүмбэр ОНӨААТҮГ	Гудамж талбайн гэрэлтүүлгийг 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн 17:30-02:30 цаг хүртэл асдаг горимд шилжүүлсэн. Мөн 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт машин мөргөж гэмтээсэн гэрэлтүүлгийн 100 метр кабель, шатсан толгойг сольж хэвийн ажиллагаанд оруулсан.	100
5.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оролцох.	11 дүгээр сарын 09 10:00 цагт	Бүх байгууллагын дарга нар	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нийт 15 байгууллагын удирдах ажилтан өөрийн биеэр оролцсон байна. Хуралд цахимаар-2, тухайн байгууллагад хамааралтай асуудал хэлэлцээгүй тул оролцоогүй-3, албан ажилтай, томилолттой-3 удирдах ажилтнууд байна.	100
Нийт дүн					87.3

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС